



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/ЗМ

Булган сум

**Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт
зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, “Амжилтын гараа хөтөлбөрийг батлах тухай” XI/76 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Амжилтын гараа” хөтөлбөрийн хүрээнд албан бус боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулахад 1,482,600 (нэг сая дөрвөн зуун наян хоёр мянга зургаан зуу) төгрөгийн санхүүжилтийг олгож, төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах зардлыг “Амжилтын гараа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Насан туршийн суралцахуйн төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Орхонтуул)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010421

Сугар Ажил 2025 о. дөр бүр Doc/2026/Захирамж

ОЧ
А.ЗМ
Аймгийн Засаг даргын 2026 оны
дүгээр сарын 28-ны/ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт



БАГШ НАРЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
СУРГАЛТАД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ (төгрөг)	Нийт дүн (төгрөг)
1	2	3	4	5
1	Сургалтын хэрэглэгдэхүүн	багц	448,000	448,000
2	Багшийн замын зардал	5 хүн	100,000	500,000
3	Байрны зардал	1	534,600	534,600
Нийт дүн:				1,482,600

--o00o--